


БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Д.ГАНЦЭЦЭГ

АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Явах чиглэл:

УЛААНБААТАР-ДОРНОГОВЬ-УЛААНБААТАР

Зам хоног, байрны зардал

Д/д	Зардлын зүйл	Тооцох зам хоног, байрны зардал	Хүний тоо	Албан томилолтын хугацаа	Нийт зам хоног, байрны зардал
1	Зам хоног /ТҮ/	14,000	1	8	112,000
2	Байрны зардал /ТҮ/	15,000	1	8	120,000
	ДҮН	29,000		8	232,000

Замын зардал

Д/д	Тээврийн хэрэгсэл	100 км-т зарцуулах норм	Явах км /2 талдаа/	1 литр шатахууны үнэ	Нийт замын зардал
1	Автомашин	16	506	2,230	180,541
	ДҮН				180,541

НИЙТ ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ

412,541

Хянасан: Ахлах нягтлан бодогч



Б.Очир

Боловсруулсан: Нягтлан бодогч



С.Лхагвасүрэн



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр.
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Д.ГАНЦЭЦЭГ ТАНАА**

2018 - 11 - 14 № 5/4547
танай _____-ны № _____-г


Үнэлгээнд оролцож ажиллах тухай

Эрүүл мэндийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтран баталсан "2018 онд хамтран хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө"-нд заасны дагуу өөрийн байгууллагын статистикийн улсын байцаагчийг Дорноговь, Говьсүмбэр аймагт 2013 оны 11 дүгээр сарын 18-аас 12 дугаар сарын 1-ний өдрүүдэд ажиллуулна уу.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцох статистикийн улсын байцаагчийн унаа, томилолтын зардлыг гаргана уу.

Батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдамж, төлөвлөгөөг хавсаргав. Хавсралт 1.5 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА

 Б.ЦОГТБААТАР



089515



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



**ХАМТАРСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖЛЫН УДИРДАМЖ**

2017 оны 12 сарын 27

№ 01

Улаанбаатар хот

1. Хяналт үнэлгээний нэр:

Орон нутгийн нэгжүүдэд цуглуулж буй анхан шатны болон тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээллийн чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээ

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний код: ХШҮ-1801

3. Үндэслэл, шаардлага:

Монгол Улсын “Статистикийн тухай” болон “Зөрчлийн тухай” хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, статистикийн мэдээ, тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ойлгох, маягтыг зааврын дагуу бүрэн нөхөх, алдаа гарсан тохиолдолд залруулгыг хэрхэн хийх, алдааны залруулгыг хийх чиглэлээр анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудад нэгдсэн ойлголт өгөх шаардлага гарч байгаа болно. Нөгөө талаас, албан ёсны статистик мэдээллийн чанар нь анхан шатны нэгжид цуглуулж, дамжуулж буй мэдээллийн чанараас шууд хамаардаг учир хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг хийх шаардлага гарч байгаа болно.

4. Зорилго, зорилт

Монгол Улсын “Статистикийн тухай”, “Зөрчлийн тухай” хуулиудын хэрэгжилтийг хангуулах, гарч болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, анхан шатнаас цуглуулж байгаа болон тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарт тавих нэгжийн дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх, ингэснээр анхан шатны болон

тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарыг улам сайжруулах, арга зүйн нэгдмэл байдлыг хангах, статистикийн салбарт ажиллаж байгаа ажилтнуудын чанарын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн туслалцаа үзүүлэх, статистикийн улсын байцаагч нарын ажлын уялдааг хангах, статистикийн төв, орон нутгийн байгууллага болон албан ёсны статистикийн анхдагч мэдээллийг гаргадаг анхан шатны нэгжийн хамтын ажиллагаа, эргэх холбоог улам сайжруулахад оршино. Хяналт үнэлгээний дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. **Нэгжийн засаглал буюу дотоод ажил¹** /Холбогдох эрх зүйн актуудыг хэрэгжүүлж байгаа үйл явц, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, албан бичиг хэргийн хөтлөлт, ажилтнуудын үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны үр дүн, ажлын байрны тодорхойлолт батлуулан мөрдсөн байдал, хүний нөөц бүрдүүлэлт, байршуулалт, ажил үүргийн уялдаа, сургалт, байгууллагын соёл, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжилт, эмх цэгц, ёс зүй, ҮСХ болон орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллаж байгаа байдал/-ыг үнэлэн гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөмж өгөх;
2. **Анхан шатны болон анхдагч мэдээлэлд тавьж буй дотоод хяналт /мэдээ тайлан гаргалт, мэдээ тайланд гарч байгаа алдаа, тэдгээрийн баримтжуулалт, засвар, мэдээ тайлан, тооллого, судалгааны анхдагч мэдээлэлд гарч буй алдаанд дүн шинжилгээ хийж байгаа байдал, ҮСХ-ноос баталсан болон зөвшөөрсөн маягт, аргачлалууд, тэдгээрийн хэрэглээ, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа байдал, тооллого, судалгааны ажлын зохион байгуулалт, судалгааны анхдагч мэдээлэл цуглуулалтанд тавьж буй хяналт, нийтлэг гарч буй алдаа, түүний залруулалт, улсын байцаагчийн хяналт, төв, орон нутгийн статистикийн газар/хэлтсүүд, статистикийн улсын байцаагч нарын болон анхан шатны нэгжийн албан хаагчдын ажлын уялдаа, эргэх холбоо, хамтын ажиллагаа, мэдээлэл нээлттэй солилцох байдал/-нд үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж өгөх;**
3. **Статистикийн мэдээллийн ашиглалт, тархаалтын үйл ажиллагаа /мэдээлэл тархаалт, сурталчилгаа, орон нутгийн хэрэглэгчдэд зориулсан сургалт, веб хуудасны баяжилт, салбар бүрийн динамик мэдээлэл бүрдүүлэлт, статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn-ийн хэрэглээ, ХАОМС, мэдээ тайлангийн программуудын ашиглалт, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа байдал/-нд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх;**
4. **Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа²**, санхүүгийн тайлагнал, батлагдсан төсөв /орлого, зардал/, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны байдал, бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тэдгээртэй

¹ Аймгийн Статистикийн хэлтэст голлон хамаарна.

² Аймгийн Статистикийн хэлтэст голлон хамаарна.

холбогдсон гэрээ хэлцлийн биелэлт, шилэн дансны мэдээлэл оруулалтын байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх;

5. Хамрах хүрээ, арга зүй, байгууллагын удирдлага, албан хаагчдын үүрэг, хариуцлага.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд төлөвлөгөөнд тусгасан 13 аймгийн аймгийн статистикийн хэлтэс, эрүүл мэндийн газар, боловсрол, соёл, урлагийн газар, биеийн тамир, спортын газар, их, дээд, сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд, нэр бүхий 67 сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан, статистикч эмч, сургууль, цэцэрлэг, соёлын төвийн мэдээ, тайлан хариуцсан ажилтнууд, 235 багийн Засаг дарга нар, багийн эмч нарын үйл ажиллагааг хамруулна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд шаардлагатай материал, лавлагаа, тайлбарыг тухайн нэгжийн удирдлага, ажилтнууд гаргаж өгөх ба ирүүлсэн мэдээ, материал, лавлагааныхаа үнэн зөвийг хариуцна.

6. Шалгуур

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, зорилттой холбогдуулан дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгоно. Үүнд:

1. Статистикийн тухай хууль
2. Зөрчлийн тухай хууль
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
4. Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд
5. Төрийн албаны тухай
6. Хөдөлмөрийн тухай
7. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм
8. Статистикийн байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм
9. Төрийн Албаны Зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны тодорхойлолтын загвар, заавар”
10. ҮСХ-ны даргын 2017 оны 12 дугаар сарын 07-ны А/200 тоот тушаалаар баталсан “Үндэсний статистикийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”
11. ҮСХ-ны даргын 2012 оны 2 дугаар сарын 21-ний 1/22 тоот тушаалаар баталсан “Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажил үүргийн ерөнхий чиглэл
12. ҮСХ-ны даргын 2017 оны 12 дугаар сарын 07-ны А/201 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Статистикийн улсын байцаагчийн дүрэм”
13. Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт MNS 5140-1:2011 стандарт
14. Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS 5140-2:2011 стандарт
15. Албан бичиг хэргийн стандарт, журмууд
16. Бусад холбогдох эрх зүйн актууд.

7. Хугацаа

Хяналт-шинжилгээ, үнэлгээг 2018 оны 3 сарын 17-ны өдрөөс 11 сарын 25-ны хооронд төлөвлөгөөнд заасан хугацаанд энэхүү удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

8. Дүнг тайлагнах, шийдвэрлүүлэх

8.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөл, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яамны Сайдын зөвлөлд тус тус танилцуулж, болзошгүй эрсдэл, зөрчлийн үр дагаврыг арилгуулах арга хэмжээний төлөвлөгөө, нэгдсэн зөвлөмжийг орон нутагт хүргүүлнэ.


8.2. Хяналт шинжилгээ, мониторингийн хэлтэс зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах бөгөөд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яаманд ажиллаж байгаа улсын байцаагч нар чиг үүргийнхээ хүрээнд хамтарч ажиллана.



**БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ**



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**



2018 ОНД ХАМТРАН ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Огноо:

2018 оны 01 сарын 02 - 12 сарын 31

Багийн бүрэлдэхүүн:

*ҮСХ-ны Тамгын Газрын ХШМХ-ийн ажилтнууд
БСШУСЯ, ЭМЯ, ЭМЯ-ны ЭМХТ-д ажиллаж байгаа
статистикийн улсын байцаагч нар,
Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтэс, газрын
улсын байцаагч, эрүүл мэнд, боловсрол, соёл, урлагийн
газарт ажиллаж байгаа статистикийн улсын байцаагч
Аймаг, нийслэл, дүүргийн хяналтын прокурорууд*

Хамрах хүрээ:

*13 аймаг, 67 сум, 235 баг
9 дүүрэг, 152 хороо
Өмчийн бүх төрлийн эрүүл мэнд, боловсролын бүх
шатны байгууллагууд
Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагууд*

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэрэгжээ, шаардлага: Монгол Улсын “Статистикийн тухай” болон “Зөрчлийн тухай” хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, статистикийн мэдээ, тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ойлгох, маягыг зааврын дагуу бүрэн нөхөх, алдаа гарсан тохиолдолд залруулгын хэрхэн хийх чиглэлээр анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудад нэгдсэн ойлголт өгөх, нөгөө талаас албан ёсны статистик мэдээллийн чанар нь анхан шатны нэгжээс цуглуулж, дамжуулж буй мэдээллийн чанараас шууд хамаардаг учир хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийх шаардлага гарч байгаа болно.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Монгол Улсын “Статистикийн тухай”, “Зөрчлийн тухай” хуулиудын хэрэгжилтийг хангуулах, гарч болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, анхан шатнаас цуглуулж байгаа болон тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарт тавих нэгжийн дотоод хяналтыг сайжруулж үр нөлөөг дээшлүүлэх, ингэснээр анхан шатны болон тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарыг улам нэмэгдүүлэх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах, статистикийн салбарт ажиллаж байгаа ажилтнуудын чанарын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн туслалцаа үзүүлэх, статистикийн улсын байцаагч нарын ажлын уялдааг хангах, статистикийн төв, орон нутгийн байгууллага болон албан ёсны статистикийн анхдагч мэдээллийг гаргадаг анхан шатны нэгжийн хамтын ажиллагаа, эргэх холбоог улам сайжруулахад оршино.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилтууд:

Дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар анхан шатны нэгжид ажиллаж байгаа албан хаагчдад туслах, зөвлөгөө өгөх;
2. Анхан шатны болон анхдагч мэдээллийг баримтжуулах, статистикийн мэдээ, тайлан гаргалтын дотоод хяналтыг сайжруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх;
3. Мэдээ, тайлангийн алдааны бүртгэл хөтлөлт, алдаа залруулгын баримтжуулалтыг тогтмол хийж хэвших чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх;
4. Мэдээ тайлан, тооллого, судалгааны анхдагч мэдээлэлд гарч буй алдаанд дүн шинжилгээ хийж сурах, хэвшихэд мэргэжлийн зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлэх;
5. Төв, орон нутгийн статистикийн газар/хэлтсүүд, статистикийн улсын байцаагч нарын болон анхан шатны нэгжийн албан хаагчдын ажлын уялдаа, эргэх холбоо, хамтын ажиллагаа, мэдээлэл нээлттэй солилцох байдлыг улам сайжруулах.

4. Хүлээгдэж байгаа үр дүн:

Статистикийн анхан шатны мэдээ тайланг цуглуулж, нэгтгэн боловсруулж байгаа ажилтнуудын статистикийн тайлан мэдээ гаргах, үнэн бодит байдлыг хангах мэдлэг, чадвар сайжирч, мэдээ тайлангийн чанарт тавих өөрийн болон дотоодын хяналт бүх шатанд сайжирч үр нөлөө нь дээшилнэ. Гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. Мэдээ тайлан гаргаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, ажлын хариуцлага нэмэгдэнэ. Ингэснээр албан ёсны статистикийн шинэчлэлт хийхэд тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулна.

5. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:


№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа		Хариуцах нэгж	Хамтран оролцох нэгж
		Эхлэх	Дуусах		
1. Орон нутагт хийх анхдагч мэдээллийн хяналт-шинжилгээ, үнэлгээ					
1	Ховд аймгийн Дарви, Зэрэг, Манхан, Жаргалант, Буянт, Ховд, Эрдэнэбүрэн сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /3-р сард/	17	24	ХШМХ	БСШУСЯ ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
2	Баян-Өлгий аймгийн Толбо, Алтанцөгц, Өлгий, Баяннуур сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /3-р сард/	24	30	ХШМХ	БСШУСЯ ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
3	Сүхбаатар аймгийн Мөнххаан, Баруун урт, Халзан, Асгат сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /4-р сард/	15	22	ХШМХ	БСШУСЯ /Статистикийн улсын байцаагч/
4	Дорнод аймгийн Чойбалсан хот, Булган, Чойбалсан сум, Цагаан овоо, Баян-Уул сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /4-р сард/	22	28	ХШМХ	БСШУСЯ /Статистикийн улсын байцаагч/
5	Хэнтий аймгийн Чингис хот, Норовлин, Батноров, Мөрөн, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /4-р сард/	28	V/5	ХШМХ	БСШУСЯ /Статистикийн улсын байцаагч/
6	Баянхонгор аймгийн Баянхонгор, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Өлзийт сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /5-р сард/	13	20	ХШМХ	ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
7	Өвөрхангай аймгийн Арвайхээр, Нарийнтээл, Хайрхандулаан, Хужирт сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /5-р сард/	20	25	ХШМХ	ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
8	Завхан аймгийн Улиастай, Цагаанхайрхан, Отгон, Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн сумдын статистикийн мэдээ, тайлан	15	23	ХШМХ	ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/


	гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /9-р сард/				
9	Архангай аймгийн Цахир, Тариат, Эрдэнэбулган, Өндөр-Улаан, Ихтамир, Цэнхэр, Хотонт сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /9-р сард/	24	X/2	ХШМХ	ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
10	Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Ханбогд, Ханхонгор, Цогт-Овоо, Өлзийт сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /10-р сард/	14	23	ХШМХ	БСШУСЯ ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
11	Дундговь аймгийн Мандалговь, Хулд, Луус, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /10-р сард/	23	XI/2	ХШМХ	БСШУСЯ ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
12	Дорноговь аймгийн Замын Үүд, Эрдэнэ, Өргөн, Айраг, Даланжаргалан сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /11-р сард/	12	21		БСШУСЯ ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
13	Төв аймгийн Баян, Сэргэлэн, Зуунмод сумдын статистикийн мэдээ, тайлан гаргалт, анхдагч мэдээллийн чанарт хяналт-шинжилгээ хийнэ /11-р сард/	21	25	ХШМХ	БСШУСЯ ЭМЯ /Статистикийн улсын байцаагч/
2. Нийслэл, дүүрэгт хийх анхдагч мэдээллийн-хяналт шинжилгээ, үнэлгээ					
14	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн эмнэлгүүдийн мэдээ, тайланд хяналт хийнэ /1-р сард/	22	31	ХШМХ	ЭМЯ ЭМХТ НЭМГ /Статистикийн улсын байцаагч/
15	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн эмнэлгүүдийн мэдээ, тайланд хяналт хийнэ /2-р сард/	21	28	ХШМХ	ЭМЯ ЭМХТ НЭМГ /Статистикийн улсын байцаагч/
16	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй бүх шатны боловсролын байгууллагын мэдээ, тайланд хяналт хийнэ /3-р сард/	12	16	ХШМХ	БСШУСЯ Нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар /Статистикийн улсын байцаагч/

17	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй, статистикийн мэдээлэлд хамрагддаг ААНБ-уудын мэдээ, тайланд хяналт хийнэ /6-р сард/	18	29	ХШМХ	НСГ Дүүргүүдийн Статистикийн хэлтэс
18	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй, статистикийн мэдээлэлд хамрагддаг ААНБ-уудын мэдээ, тайланд хяналт хийнэ /11-р сард/	27	30	ХШМХ	НСГ Дүүргүүдийн Статистикийн хэлтэс
8	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй бүх шатны боловсролын байгууллагын мэдээ, тайланд хяналт хийнэ /12-р сард/	3	7	ХШМХ	БСШУСЯ Нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар /Статистикийн улсын байцаагч/


6. Замын зураглал


а. УБ-Ховд-Баян-Өлгий-УБ







б. УБ-Сүхбаатар-Дорнод-Хэнтий-УБ







в. УБ-Баянхонгор-Өвөрхангай-УБ





г. УБ-Завхан-Архангай-УБ





**УСХ-НЫ ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭС**

2017-12-08